



## **АГАР ТАЙЖ ХХК**



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ АГАР ТАЙЖ ХХК-Н  
“КАРТОНОН ЦААС БОЛОВСРУУЛАХ” ТӨСЛИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар 2023 он

БАТЛАВ.

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА: \_\_\_\_\_ Б.БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.

“АГАР ТАЙЖ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

\_\_\_\_\_ EERDUNBAOLIGAO

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНД ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЯВУУЛДАГ “АГАР ТАЙЖ” ХХК-ИЙН “КАРТОНОН ЦААС  
БОЛОВСРУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/ АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР 2716941 /

Хянасан :

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ: \_\_\_\_\_ П.ШИНЭЦЭЦЭГ

Боловсруулсан :

“АГАР ТАЙЖ” ХХК-ИЙН САНХҮҮ, МЕНЕЖМЕНТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

\_\_\_\_\_ А.АРИУНЗАЯА

## ГАРЧИГ

НЭГ. АГАР ТАЙЖ ХХК-Н ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1.Түүхэн товчоон.....	6
1.2. Бүтээгдэхүүн үйдвэрлэл .....	6
1.3. Үйлдвэрийн орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил.....	7
1.4. Техник технологи.....	8
1.5. Төслийн хүчин чадал .....	12
1.6. Агар тайж ХХК-н Байгаль орчны үнэлгээ .....	12
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	13
2.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл .....	13
2.2. Төслөөс хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдал,үнэлгээ.....	13
2.3. Төслөөс ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал,үнэлгээ .....	14
2.4. Төслөөс амьтны аймагт нөлөөлөх байдал,үнэлгээ .....	14
2.5. Төсөл хэрэгжих орчны түүх, соёлын дурсгалт зүйлс .....	14
2.6. Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл.....	14
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УЙДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ, АРИЛГАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	16
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	16
3.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах .....	16
3.3. Ногоон байгууламжийн зөвлөмж, технологийн зааварчилгаа.....	16
3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах .....	16
3.5. Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг, бууруулах .....	16
3.6. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж .....	17
3.7. Техник технологийн арга хэмжээний ерөнхий зөвлөмж.....	17
3.8. Удирлага зохион байгуулалт.....	17
3.9. Хатуу хаягдлыг түр хураах байгууламж ашиглах.....	17
3.10. Төслийн талбай болон агуулахад ариутгал, халдваргүйтэл хийх зөвлөмж .....	18
3.11. Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, нийгэм хамгаалал .....	18
3.12. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй .....	19
3.13. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг зайлуулах.....	19
3.14. Эрсдэлийн хор хөнөөллийг бууруулах,арилгах талаар авах арга хэмжээ .....	19
ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
ТАВ . ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	24
ЗУРГАА . ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөө-2023

ДОЛОО. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	27
ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	30

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Агар тайж компани (ХХК)-ийн мэдээлэл .....	5
Хүснэгт 2. “Агар тайж” ХХК-ийн албан тушаалтнуудын мэдээлэл .....	6
Хүснэгт 3. Үйлдвэрлэлд хэрэглэх түүхий эд / хугацаагаар / .....	6
Хүснэгт 4. Туслах түүхий эд материал .....	6
Хүснэгт 5. Эцсийн бүтээгдэхүүн. ....	7
Хүснэгт 6. Тоног төхөөрөмжийн мэдээлэл .....	8
Хүснэгт 7. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал.....	12
Хүснэгт 8. “Агар тайж” ХХК-н БОННУ-ийн батлагдсан тайлангууд. ....	12
Хүснэгт 9. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх байдал ,үнэлгээ .....	13
Хүснэгт 10. Төслөөс хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдал,үнэлгээ.....	13
Хүснэгт 11. Тухайн төслөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл .....	14
Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүснэгт .....	21
Хүснэгт 13. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүснэгт .....	24
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүснэгт .....	25
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	27

## Зургийн жагсаалт

Зураг 1. Үйл ажиллагаа явагдаж буй газрын тойм зураг .....	5	
Зураг 2. Дусаагүй үйлдвэрлэл	Зураг 3. Үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүн.....	7
Зураг 4. Ээдэм бэлтгэх тогоо	Зураг 5. Ээдэм цэвэршүүлэгч.....	9
Зураг 6. Ээдэм цэвэршүүлэгч	Зураг 7. Цэвэршүүлэгч шигшүүр .....	10
Зураг 8. Индүүдэгч машин, цавуудагч машин	Зураг 9. Ороогч захлагч машин .....	10
Зураг 10. “Агар тайж” ХХК-ний хаягдал цаас боловсруулах үйлдвэрийн технологийн бүдүүвч.....		11
Зураг 11. Үйлдвэрийн тоног төхөөрөмж.....		12
Зураг 12. Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа, Байгаль Орчины хэлтэсийн зохион байгуулалт.....		29

## Товчилсон үгийн тайлбар

БОАЖЯ	Байгаль орчин аялал жуучлалын яам
БОННУ	Байгаль орчины нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
ЭМААБО	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

### НЭГ. АГАР ТАЙЖ ХХК-Н ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Агар тайж ХХК нь хоёрдогч түүхий эд болох хаягдал картонон цаасыг худалдан авч дахин боловсруулдаг үйлдвэр юм. Манай компани нь Хан-Уул дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Ноост трейд ХХК-н байрыг түрээслэн үйл ажиллагаа явуулж байна.



1.

\_\_\_\_\_:

1.

( )-

Картонон цаас боловсруулах аж ахуйн нэгж	Аж ахуйн нэгжийн улсын бүтгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Агар тайж ХХК-н хаяг байршил
Агар тайж компани (ХХК)	000167968	Картонон цаасыг дахин боловсруулах	Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 20-р хороонд

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

			байрлах Ноост трейд ХХК-н байр
--	--	--	--------------------------------

2. “ ” -

№	Нэр	Албан тушаал
1	Eerdunbaoligao	Агар тайж ХХК-ийн Хөрөнгө оруулагч Ерөнхий захирал
2	Huricha	Агар айж ХХК-ийн Гүйцэтгэх захирал
3	А.Ариунзаяа	Агар тайж ХХК-ийн санхүү, менежмент хариуцсан ажилтан

1.1.Түүхэн товчоон

Агар тайж ХХК 2002 онд Агар нэртэй ариун цэврийн цаас үйлдвэрлэж дотоодын зах зээлийг ханган ажилладаг байсан. 2017 оноос эхлэн үйл ажиллагааныхаа чиглэлийг өргөтгөж хаягдал картонон цаасыг худалдан авч дахин боловсруулж цаасан хайрцагны түүхий эдийг бэлдэж дотоодын зах зээлд нийлүүлэнэ ажиллаж байна. Агартайж ХХК нь 2017 оноос Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших Ноост трейд ХХК-н 1100 мкв байрыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулдаг. Үйлдвэрийн цех-864 мкв талбайтай. Үүнд цаас боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах тоног төхөөрөмжүүд агуулагдана. Түүхий эд агуулах-650 мкв талбайтай Бэлэн бүтээгдэхүүн агуулах -122 мкв талбайтай.

1.2. Бүтээгдэхүүн үйдвэрлэл

Үйлдвэрийн түүхий эд нь хаягдал цаас юм.Үйлдвэр нь хоногт 20-26 тонн хаягдал цаас боловсруулж 9-14 тонн рулонтой бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

3. / /

№	Түүхий эд	Хэрэглээ, тонн		
		Хоног	Сар	Жил
1	Хаягдал цаас	20-26	440-572	4940-6422

" 0

Хаягдал цаасыг боловсруулахад барьцалдуулах зорилгоор хүнсний крахмал болон ус уурыг ашигладаг.

Усны хэмжээг БОЯ-ны 1995 оны “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах түр норм”-ын дагуу тооцлоо.Тус нормоор 1 тонн хаягдал цаас боловсруулахад 45 м.куб ус хэрэглэнэ.

4.

№	Түүхий эд	Хэмжих нэгж	Боловсруулах хаягдал цаасны хэмжээ, тонн	Усны хэрэглээ, мкв		
				хоног	сар	жил
1	Ус	тонн/хоног	9.0	405	8910	100035
2	Уур			10	210	2520

" " " 0

Завсрын бүтээгдэхүүн үүсэхгүй.Эцсийн бүтгээдэхүүн 700-1200 кг рулон /ороосон/ цаас, захиалагчийн хэмжээнээс шалтгаалан өргөн жин хэлбэлзэнэ.



№	Хэрэглээ	Хэмжих нэгж	Хоногт	Сард	Жилд
1	Гарах бүтээгдэхүүн	тонн	8.0-10.0	176.0-220.0	1.408.0-2.200.0

Тус бүтээгдэхүүн нь “Хоёрдогч түүх эд, хаягдал цаасны техникийн нөхцөл” MNS 2153:1983 стандартын хангаж байгааг НМХТ лабораторын шинжилгээний дүнгээр тодорхойлсон байна.

### 1.3. Үйлдвэрийн орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил

“Хаягдал цаас дахин боловсруулах үйлдвэр” нь Хан-Уул дүүргийн 20-р хороо “Ноос трейд” ХХК-ний байранд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хойд тал нь мөн “Ноос трейд” ХХК-ний өөрийн үйлдвэрийн байр байх бөгөөд зүүн талд нь үслэг эдлэлийн “Сор” ХХК-ний урд талд нь Сүлжмэлийн үйлдвэр, баруун талын хашаа нь төмөр зам дагуу байралсан зэрэг жижиг үйлдвэрүүд төвлөрсөн бүсэд байрлана.

\_\_\_\_\_ . Үйлдвэрийн талбай нийслэлийн Хан-Уул дүүрэг 20-дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах бөгөөд төвийн эрчим хүчний системд холбогдсон.

\_\_\_\_\_ . Улаанбаатар хотод байрлалтай тул автозамын сүлжээ сайн, улсын чанартай автозамд хялбархан холбогдоно.

\_\_\_\_\_ . Улаанбаатар хотод байрлалтай тул бүх төрлийн харилцаа холбоонд сайн холбогдоно.

\_\_\_\_\_ . Тус үйлдвэр нь технологийн болон унд ахуйн хэрэгцээгээ “Ноос трейд” ХХК-ний худгаас хангадаг. Мөн бохир усны нэгдсэн системд холбогдсон.

\_\_\_\_\_ . Тус үйлдвэрийн байр нь төвийн халаалтын системд холбогдсон.



2.



3.

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

1.4. Техник технологи

“Хаягдал цаас дахин боловсруулах үйлдвэр”-ийн тоног төхөөрөмжийн жагсаалтын доорх хүснэгтээр харуулав.

6.

№	Төхөөрөмжийн зориулалт	Марк	Хүчин чадал
1	Ээдэм бутлагч	Pulping equipment 880	380v/50 Hz, мотор 45kw
2	Ээдэм цэвэршүүлэгч	Pulping equipment 550	380v/50Hz, мотор 45kw
3	Ээдэм цэвэршүүлэгч шигшүүр	Pullscreen	380v/50Hz, мотор 45kw
4	Ээдмийн хог цэвэрлэгч 16 хошуутай төхөөрөмж	Pulping equipment 550	380v/50Hz, мотор,цагт 350м3 зутанг шүүнэ
5	Цаасны машин /индүүдэгч, цавуудагч	Pullscreen	380v/50Hz, мотор18.5kw
6	Индүүдэгч машин	Hang Zhou Fu yang Heng Wei	380v/50Hz, мотор18.5kw
7	Цавуудагч машин	Hang Zhou Fu yang Heng Wei	380v/50Hz, мотор18.5kw
8	Ороогч, захлагч машин	Hang Zhou Fu yang Heng Wei	380v/50Hz, мотор18.5kw

Тус үйлдвэрийн хоногийн бүтээмж нь цаасны машины хүчин чадлаас шууд хамааралтай байдаг. Үүнээс :

- J Гадна гарсан бүтээгдэхүүн тээвэрлэх “Хино” маркийн ачааны автомашин-1,
- J ковш-1,
- J по-1 тус тус ашигладаг.

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023



4.



5.



“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

6.


7.



8.

9.

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023




10. “ ” -

Хаягдал цаасыг ээдэм зуурагчаас дамжуулж уусмалын тогоонд өгөгдөнө, эндээс доргиурт шигшүүрт ээдмийн хог хаягдалаас хамаарч хувиарлагдана. Доргиурт шигшүүр хүндийн хүчний үйлчлэлээр устай нэгдсэн хүнд цаас нь доош тунан шүүгдэж, хөнгөн хог хаягдал шүүгдсийн дээр тунаж үлдэнэ. Тунаж үлдсэн хог хаягдлыг хамаж үйлдвэрийн талбайд байрлах хогийн цэгт хадгалагдана.

Шүүгдэж үлдэх ээдэм нь угаах санд өгөгдөнө. Тээрмийн хүчин чадлыг хангах үүднээс 2 угаах сан суурьлуулсан. Угаах санд ээдэмд агуулагдах төрөл бүрийн тоос, тоосонцор болон бусад төрлийн доргиурт шигшүүрт шигшигдээгүй үлдсэн хог хаягдал угаагдана. Ээдмийг нарийн ширхэгтэй болгож нягтруулах зорилгоор 75кВт хүчин чадалтай мотор бүхий тээрмийн машинд өгөгдөнө. Цаасны машин ээдмийг зуурамтгай цавуу, /крахмал/ зуурч хатаах, индүүдэх замаар эцсийн бүтээгдэхүүний бэлдэц бэлэн болно. Энэхүү бэлдэцэд наалдсан тоос, тоосонцор бусад эгэл хэсгийг угаах зорилгоор усаар шүршинэ. Усаар шүрших үед гравитацийн болон төвөөс зугтах хүчний үйлчилэлээр ус нь эргэлтийн усны нөөцлүүрт өгөгдөнө. Цаасны машинаас гарах бэлдэцийг ороох, захлах машинаар дамжин шошго, тэмдэглэгээ хийгдэж бүтээгдэхүүн хадгалах агуулахад шилжинэ.

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023



11.

1.5. Төслийн хүчин чадал

Агар тайж ХХК нь хоногт 20 тонн картонон хайрцагны цавуутай болон цавуугүй бэлдэц цаас үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд жилд 288 хоног ажиллах төлөвлөгөөтэй.

7.

№	Ажлын горим	Хүчин чадал, тонн
1	1 хоногт 12 цаг	8.0-10.0
2	1 сард 22 хоног	176.0-220.0
3	1 жилд 261 хоног	1.408.0-2.200.0

1.6. Агар тайж ХХК-н Байгаль орчны үнэлгээ

“Агар тайж ХХК” нь 2007 оноос хойш 3 удаа БОННУ хийлгэсэн байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа БОННУ-ний тайланг доорх хүснэгтээр үзүүлэв .

8.

№	БОННУ-н тайлангийн нэр	Батлагдсан он
1	“Ариун цэврийн цаасны үйлдвэр” төлсийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан	2007 он
2	“Ариун цэврийн цаасны үйлдвэр” төлсийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан	2013 он
3	“Картонон цаас боловсруулах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан	2019 он

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Тухайн төсөл нь Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжих бөгөөд төслийн үйл ажиллагаанаас үүдэн дотоод болон гадаад оринд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

9.

НӨЛӨӨЛӨЛ	Нөлөөллийн үр дагаварын үнэлгээ				
	Маш бага буюу нөлөөгүй	бага	Дунд	Их	Онц Аюултай
Химийн бодисыг хадгалах үед агуулахад химийн бодис урших дотоод агаарын бохирдол үүсэх		+			
Ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх	+				
Агуулахын дотоод орчиноос гадагш агаарын бохирдол алдагдах	+				
Химийн бодисыг зөөж тээвэрлэх болон агуулахаас ачих, буулгах тээврийн хэрэгслээс ялгарах утаа орчинд нөлөөлөх		+			
Нийт нөлөөллийн 50% бага 50% маш бага буюу нөлөөгүй гэсэн үр дагавартай байгаагаас төслөөс агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ.					

### 2.2. Төслөөс хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдал, үнэлгээ

Тус төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл бага түвшинд байна.

10.

НӨЛӨӨЛӨЛ	Нөлөөллийн үр дагаварын үнэлгээ				
	Маш бага буюу нөлөөгүй	бага	Дунд	Их	Онц Аюултай
Ахуйн хог хаягдлыг тогтоосон цэгээс өөр газарт хаяж, хөрс бохирдуулах		+			
Газрын хөрсөн дээр агуулахаас химийн бодисыг		+			

**“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023**

Зөөж санамсаргүй	тээвэрлэх асгарч хаягдах	үед				
Нийт нөлөөллийн 100% “бага” гэсэн үр дагавартай байгаагаас агуулахаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ.						

**2.3. Төслөөс ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ**

Тус Хан-Уул дүүргийн нутагт хэрэгжих “Агар тайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

**2.4. Төслөөс амьтны аймагт нөлөөлөх байдал, үнэлгээ**

Тус Хан-Уул дүүргийн нутагт хэрэгжих “Агар тайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

**2.5. Төсөл хэрэгжих орчны түүх, соёлын дурсгалт зүйлс**

Тухайн төслийн барилга байгууламжийн ойролцоо буюу эдэлбэр газарт түүх дурсгалын зүйлс болон археологи, палеонологийн олдвортой газар байхгүй. Иймд энэхүү төслийн үйл ажиллагаанаас түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи палеонтологийн олдворт ямар нэгэн байдлаар сөрөг нөлөөлөл байхгүй юм.

**2.6. Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл**

Дээр дурьдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллүүдийг нэгтгэн авч үзлээ. Ингэж нэгтгэсэнээр байгаль орчинд у төсөл хэрэгжсэнээр ямар нөлөө үзүүлэхийг нийтэд нь үнэлэхэд, уг нөлөөллүүд ямар хувьтай болох нөлөөллийн цар хүрээ нь ямар байх гэдгийг тогтооход дөхөм болдог. Иймээс өмнөх бүлгүүдэд авч үзсэн бүхий л орчин дахь сөрөг нөлөөллүүдийг нэгтгэн хүснэгтэд үзүүлэв.

**II.**

Байгаль орчин	Нөлөөллийн эрчим, цар хүрээ					
	Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц аюултай	Нөлөөллийн зэрэг
Агаарын чанарт нөлөөлөх байдал	-2	-2				Бага
Газрын гадарга, хэвлий						Нөлөөлөлгүй
Хөрсөнд нөлөөлөх байдал		-2				Бага
Гадаргын болон газрын доорх ус						Нөлөөлөлгүй
Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал						Нөлөөлөлгүй
Амьтны аймаг						Нөлөөлөлгүй
Түүх соёлын өв						Нөлөөлөлгүй
<b>Нийт</b>	-1	-3				Бага
Хувь /% /	30%	70%				



“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

Дүгнэлт	Нийт үнэлгээ нь 30% нь маш бага буюу нөлөөлөлгүй 70 % нь бага нөлөөтэй гэсэн ангилалд хамрагдаж байгааг үндэслэн уг төслөөс байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг “Бага” гэж үзэхээр байна.
---------	--

## ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УЙДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БУУРУУЛАХ, АРИЛГАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

### 3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.

- ✚ Агуулахын ажлын байр болон гадна орчноос орчны хяналт шинжилшээнд заасны дагуу агаарын дээж авч шинжлүүлж, орчны бохирдлын бие даасан суурь үнэлгээ хийлгэх
- ✚ Тоосжилт ихтэй хэсэгт ажиллах ажилчдад хошуувч олгож хэрэгжүүлж хэвшүүлэх
- ✚ Агуулахын барилгад тогтмол чийгшил болон дулааны температурын хэмжээг хянаж байх тоног төхөөрөмж байрлуулах
- ✚ Дулааны нөлөөгөөр хортой хий ялгаруулдаг шигэн болон хатуу бодисууд гадна орчн хэт халуун температурын улмаас агаар хий ялгаруулж, үүний улмаас агаарын чанарын найрлага алдагдан бохирддог. Агаарын чанарын үзүүлэлтүүийг хянаж байхын тулд агаарын найрлага Монгол улсын агаарын чанарын стандарт мөрдөх.

### 3.2. Хөрсөн бүррхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Агуулахад хадгалагдаж буй бодисууд гэнэтийн ослын улмаас асгарч алдагдахад хүрвэл агуулах болон хашаны ихэнх талбай нь цементээр хучигдсан тул алдагдсан хуурай бодисыг буцааж хураан авахад боломжтой.

- ✚ Химийн болис аюултай материалын хадгалалт ашиглалтанд байнга хяналт тавьж байх
- ✚ Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх
- ✚ Агуулахын хашаан доторх цементлэгдээгүй хэсэг газрын шимт хөрсөөр ургамалжуулж чимэглэлийн мод бут тарин , ногоон байнууламж байгуулан арчилж хамгаалах

### 3.3. Ногоон байгууламжийн зөвлөмж, технологийн зааварчилгаа

Хан-Уул дүүргийн нутагт хэрэгжих “Картонон цаас боловсруулах” төслийн агуулахын хашаан доторх ногоон байгууламжийн төслийг төвлөхөд Монгол улсын Стандарт “Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах” MNS:6020:2011 стандарт, ногоон байгууламжтай холбоотой барилгын норм дүрмийг баримтална.

### 3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотойгоор осол аваар нь голдуу аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас үүдэлтэй байдаг байна.Химийн хортой бодисыг тээвэрлэх болон хадгалах үйл ажиллагаа зөрчигдсөнөөс болж ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл үүсэх юм. Иймээс химийн бодисыг тээвэрлэх болон хадгалах журамд заагдсаны дагуу алдаж, асгахаас сэргийлэх арга хэмжээг тогтмол авч байх шаардлагатай.

### 3.5. Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг, бууруулах

Уг төслийн зүгээс нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцануй бага бөгөөд харин уг агуулахад ажилладаг ажилчдад үзүүлж болох сөрөг нөлөөллийг бууруулахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- ✚ Ажилчдын эрүүл мэндийн асуудал хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр хангах
- ✚ Химийн бодисын нийлүүлэлтийн үед аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр дагалдуулан өгөх

## “Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

- ✚ Ажилчдын эрүүл мэндийг үзлэгт хамруулах
- ✚ Хэт их жижиглэнгийн худалдаа хийхгүй байх

### 3.6. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Тус байгууллагад гарч болзошгүй ослыг бүүрэн хэмжээгээр сэргийлэн зогсоох техникийн нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үйл ажиллагааныхаа эхэн үеэс иж бүрнээр авах нь хамгаас чухал болно. Тиймээс сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, мөн цаашид гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс хамгаалахын тулд тухайн орчин тус бүрийн хувьд арга хэмжээнүүдийн зөвлөмж, саналуудыг энэ бүлэгт оруулсан болно. Эдгээр зөвлөмж саналыг цаг тухай бүрт нь хэрэгжүүлэхийг “Агар тайж” ХХК-д удирдлага болгон зөвлөж байна.

### 3.7. Техник технологийн арга хэмжээний ерөнхий зөвлөмж

Төсөл хэрэгжих нутаг дэвсэрийн агаар хөрс зэрэг орчны бохирдолт байгаль орчин нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь гол төлөв техник технологийн буруу үйл ажиллагаа эвдрэл гэмтэл санамсаргүй үйл ажиллагаанаас болдог. Иймээс төслийг хариуцан ажиллуулах “Агар тайж” ХХК-ийн удирдлагад төслийн үйл ажиллагааны дүрмийг боловсруулж мөрдөх ажлыг гардан хариуцаж ажиллах шаардлагатай. Мөн боловсруулсан дүрмээ сурталчилгааны бүх хэлбэрийг ашиглан таниулах ажлыг тус байгууллагын захиргаа хариуцахын зэрэгцээгээр болзошгүй аюул ослын үед түүнийг хор хөнөөлийг багасгах арилгах боломжит техник хэрэгслээр урьдчилан хангасан байх шаардлагатай.

### 3.8. Удирдлага зохион байгуулалт

- ✚ Байгаль орчныг хамгаалах чиглэлээр өөрийн ажилтан, ажилчдын дунд сургалт семинарыг тогтмол зохион байгуулах
- ✚ Болзошгүй аваар ослын үед хэрэглэх анхны тусламжийн материал / өвчин намдаах эм, ариутгасан спирт, цэвэр боолт гэх мэт /
- ✚ Гал түймэр, үер усны аюул зэрэг ослын үед авагдах арга хэмжээний зөвлөмжийг гарагж үйл ажиллагаандаа мөрдлөг болгох
- ✚ Жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө байгаль хамгаалах, мод сөөг тарих, сөрөг нөлөөг таслан зогсоох, зардлыг тусган төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.
- ✚ Гал унтраах хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж шаардлагатай газар байрлуулах ба тоног төхөөрөмжүүдийг галн хороор хангах.

### 3.9. Хатуу хаягдлыг түр хураах байгууламж ашиглах

Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа химийн бодисын сав баглаа боодлын хатуу хог хаягдлуудыг зориулалтын агуулахад аюулгүйгээр цуглуулан хадгалж, химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай гэрээ хийн гэрээний дагуу тогтмол хугацаанд зайлуулна.

Мэргэжлийн байгууллага хог хаягдлыг хүлээж аван, устгалд оруулахаар агуулахаас тээвэрлэн зайлуулах хүртэл өөрийн агуулахад хадгалахдаа Химийн хорт болон аюултай бодис хадгалах тээвэрлэх ашиглах устгах журам-ын дагуу хадгалж байх шаардлагатай.

Ахуйн хатуу хог хаягдлын цэгийн байршлыг сонгохдоо салхины ноёлох чиглэл, газрын хэвлий эрүүл ахуйн бүсийн зөвшөөрөгдөх зай хэмжээ зэргийг харгалзан байрлуулах шаардлагатай.

## “Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

- ✚ Хатуу хог хаягдлын төрлүүдэд зориулсан сав байрлуулах
- ✚ Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
- ✚ Хуванцар сав лааз / хоёрдогч түүхий эд /
- ✚ Бие засах газрын хаягдал
- ✚ Бусад

Уг төслийн үйл ажиллагаа эхэлмэгц Хан-Уул дүүргийн Үйлдвэрлэл, тохижилт үйлчилгээний хэлтэстэй Хатуу хог хаягдлыг тээвэрлэн зайлуулах талаар гэрээ хийж гэрээний дагуу ажиллах.

### 3.10. Төслийн талбай болон агуулахад ариутгал, халдваргүйтэл хийх зөвлөмж

Агуулахын байранд зайлшгүй хийх дотоод зохион байгуулалт

- ✚ Цэвэр бохир усан хангамжай байх
- ✚ Барилгын ханын зузааныг хөлрөлт буюу хөгц үүсэхгүй нөхцөл, цан цохихгүй байдлаар
- ✚ Дотор өнгөлгөөний хувьд хана нь угааж арчих ариутгахад хялбар материалаар хийгдэх
- ✚ Шал нь угааж ариутгал хялбар гадаргуу жигд хөдөлгөөнгүй нүх сүвгүй плита / зориулалтын / мазакан шал байх
- ✚ Бэлэн бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр барааны нэр төрөл жин өнгө зэрэг шошгын мэдээллийг тодорхой тавьж өгөх
- ✚ Ажилчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж байх

Төслийн үйл ажиллагааны явцад агуулахад тодорхой хэмжээгээр үнэрийн бохирдол хөгц мөөгөнцөр элдэв төрлийн шавьж мэрэгчид үүрлэх нөхцөлтэй байдаг. Эдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх элдэв төрлийн гэдэсний халдварт өвчин харшил зэргийг үүсгэх тул ажлын байранд ариутгал халдаргүйжүүлэлтийг сард нэг удаа мэргэжлийн байгууллагаар тогтмол хугацаанд хийлгэж байх шаардлагатай.

### 3.11. Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, нийгэм хамгаалал

Болзошгүй аюул ослын үед ашиглах зориулалтын бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл хор сармагжуулах бодис, уусмалыг ажлын байранд байрлуулах ба химийн бодистой харьцаж ажилладаг хүн нэг бүрийг арьс болон амьсгал хамгаалах зориулалт бүүхий, стандартын шаардлага хангасан хүн нэш бүрийн хамгаалалтын хэрэгслээр хангасан байна.

- ✚ Ажлын байр нь тухайн агуулахын эзлэхүүн хадгалж байгаа бодисуудын дэгдэмтгий чана, хортой болон аюултай байдлын зэрэглэл, тоо хэмжээнд зохицуулан сонгож авсан хүчин чадал бүхий агааржуулалтын системтэй байлгах
- ✚ Химийн бодисын агуулахад хүнсний зүйл хадгалах, хэрэглэхийг хориглох
- ✚ Химийн бодисой харьцаж байгаа ажилтнуудыг нормын сүү, таргаар тогтмол хангах
- ✚ Ажилчдаа жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж дүгнэлт гаргуулж байх
- ✚ Химийн бодист харшилтай, жирэмсэн, сэтгэц мэдрэлийн хувьд эрүүл биш хүнийг агуулахад ажиллуулахгүй байх.
- ✚ Ажилтнууддаа харшил болон хордох шинж тэмдэг ажиглагдсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авч, эмчийн үзлэгт даруй оруулах, шалтгааныг арилгах арга хэмжээг ажлын байрныхаа хувьд авч хэрэгжүүлж байх.

### 3.12. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй

- ✚ Хадгалалтын процесс, машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлагыг хангасан байх
- ✚ Цахилгаан тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдан байх, цахилгааны ашиглалт аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байх
- ✚ Галын аюулгүй байдлыг хангах, дотоод дүрмийг сахих, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгах, тэдгээрийг ажиллагсдад ашиглуулж сургах
- ✚ Аюул ослоос урьдчилан хамгаалах, эрчим хүчний эх үүсвэрийг дахин залгах үед өөрөө залгагдахгүй хэрэгслээр хангагдсан байхаар тоноглогдсон байна.
- ✚ Химийн бодистой харьцаж ажиллагсдыг сургалтанд / бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө гэх мэт хамруулж гарын үсэг зуруулсаны дараа ажиллуулах ба сургалтанд хамрагдаагүй тохиолдолд хисийн бодистой харьцаж ажиллуулахгүй байх.
- ✚ Агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна

### 3.13. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг зайлуулах

Химийн бодисийн үлдэгдэл хаягдал хаяг нь мэдэгдэхгүй болсон бодис хугацаа дууссан болон ашиглалтаас гарсан гэх зэрэг олон шалтгаанаас үүдэн тэдгээрт устгал хийх шаардлагатай болсон тохиолдолд гарсан хог хаягдлуудыг түр зориулалтын агуулахад аюулгүйгээр цуглуулан халгалж, химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай гэрээ хийн гэрээний дагуу тогтмол хугацаанд зайлуулна. Ажлын байранд химийн бодисын тохирсон саванд хийж, зөв шошголсон, химийн аюулгүй ажиллагааны тоо баримтын хуудастай байлгах.

- ✚ Химийн бүх бодисыг тохирсон саванд хийжж зөв шошголсон, химийн аюулгүй ажиллагааны тоо баримтын хуудастай байлгах
- ✚ Бүх ажилчдыг химийн бодисыг аюулгүй хэрэглэх , хадгалах талаар мэдээлэл зааварчилгаагаар хангах
- ✚ Хяналтыг сайжруулахын тулд хамтын ажиллагааг сайжруулах
- ✚ Хувийн хамгаалах хэрэгслээр хангах, хэрэглэх, арчлах арга хэмжээг зохицуулах
- ✚ Сургалтын хөтөлбөрийг төлөвлөж хэрэгжүүлэх.

### 3.14. Эрсдэлийн хор хөнөөллийг буруулах,арилгах талаар авах арга хэмжээ

- ✚ Химийн бодисыг худалдаалахдаа БОАЖЯ-аас ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжид худалдана.
- ✚ Химийн бодисыг хадгалах ашиглах худалдах үйлдвэрлэх импортлох зохих журмын дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байх
- ✚ Химийн бодисын хаяг шошго бар кодыг эрх бүхий байгуулагаар гаргуулах
- ✚ Химийн хортой болон аюултай бодисыг ашиглахын өмнө эрсдлийн үнэлгээг заавал хийлгэсэн байх
- ✚ Хаалт тагны битүүмж алдагдаж ууршилт явагдах, үүнээс үдэнн хий алдагдаж ажлын байр агуулахад хортой аюултай хий хуримтлагдахаас сэгийлэх

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

- ✚ Үйлдвэрийн байранд аюулын шүршүүр нүд угаах төхөөрөмжийг яаралтай цэгүүдэд хангалттай хэмжээгээр байршуулах
- ✚ Бодисуудын хор аюулын зэргийг илэрхийлсэн анхааруулга тэмдэглэгээ эрсдэлийн тэмдэг (R-8, R-25, R-50) зэргийг тод томоор хийж зохих газарт байрлуусан байх.
- ✚ Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн болон хүний амь нас эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд тэдгээрийг нэн даруй арилгах.

**ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Агар тайж” ХХК-ийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

12.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө						
Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг 1 жил / төг /	Нийт зардал 1 жил	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>1. Агуулахын дотоод агаарын чанар</b>						
Агуулахын агааржуулалтын хэвийн ажиллагаа алдагдсанаас ажлын байрны агаар бохирдоно. Химийн бодисыг хадгалах үед агуулахад химийн бодис уурших дотоод агаарын бохирдол үүсэх Агуулахын дотоод орчноос гадагш агаарын бохирдол алдагдах Түүхий эдүүдийг тээвэрлэн ирж буулгах, бүтээгдэхүүнийг ачиж явах үед тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас гарах хорт хий / азотын давхар исэл, хүхэрлэг хий, хар тугалга / утаа гадна агаарын чанарт нөлөөлнө.	Агуулах байрыг тогтмол шалгаж, засуур үйлчилгээг тогтмол хийж байх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардлаар		Үйл ажиллагааны туршид	“Агаарын тухай хууль” MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага  MNS4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуй шаардлага
<b>2. Хөрсөн бүрхэвч</b>						
Ахуйн хог хаягдлыг тогтоосон цэгээс өөр газарт хаяж, хөрс бохирдуулах Газрын хөрсөн дээр агуулахаас химийн бодисыг зөөж тээвэрлэх үед санамсаргүй асгарч хаягдах	Ахуйн хатуу хог хаягдлыг тогтоосон хогийн цэгт цуглуулан ачуулж байх ангилсан хогийн цэг байгуулах	Агуулахын хашаан дотор  Агуулахын хашаан доторх хөрсөн орчин	500,000  800,000	800,000	Үйл ажиллагаа эхлэхэд	Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байрлуулах, тээвэрлэх, аюулгүй болгох,

“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

	Агуулахын хашаан доторх цементлэгдээгүй хэсэг газрыг хиймэл хөрсөөр хучин ургамжуулж чимэглэлийн мод бут тарин арчилж хамгаалах	ахуйн хог хаягдлын цэг			Жилийн эхэнд	хадгалах ,устгах журам. ЗГ-ын тогтоол №135.2002 Хог хаягдлын тухай хууль 2017 он
<b>3. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа</b>						
Болзошгүй осол аваар гарах, ажиллагсад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөнөөс аюул осолд өртөх	Ажилчдын ажлын хувцас багаж хэрэгслээр хангах Ажлын байранд анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулах Химийн бодистой анхаарал болгоомжтой ажиллах, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулж байх, шинээр ажилд орох хүмүүсийг шалгаж сургаж байх Эрүүл мэндийн үзлэгт ажилчдаа хамруулах Ажилчдыг хор саармагжуулах сүү таргаар хангах Хэрэглэгчидэд өөрийн тээврийн хэрэгслээр химийн бодис авсан	Бүх ажилчидад  Химийн бодистой харьцдаг ажилчдад  Харилцагчидад  Бүх ажилчидад		Үйл ажиллагааны зардал багтана  Дотоод төлөвлөлтөөр  Дотоод төлөвлөлтөөр	Жилийн турш  Жилийн турш    Жилийн турш	
			500,000	500,000		



“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

	<p>тохиолдолд                  аюулгүй                  ажиллагааны талаар                  тогтмол                  анхааруулах                  Аюулгүй ажиллагаа                  бодисын хадгалалт,                  хамгаалалтын                  талаар гамшигаас                  урьдчилан                  сэргийлэх хяналтын                  болон байналь                  орчны байцаагчаар                  хянуулж байх                  Мэргэжлийн                  байгууллагатай                  хамтран хөдөлмөр                  хамгаалал , байгаль                  орчныг хамгаалах,                  гал түймрээс                  урьдчилан                  сэргийлэх талаар                  ажил эхлэхийн өмнө                  сургалт                  сурталчилгааг хийх</p>			500,000		
Нийт				2100,000		

**ТАВ . ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

13.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө						
Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Химийн боис урвалжууд санамсаргүйгээр асгарах, гадагш алдагдах	Химийн бодисын бүртгэл зарцуулалтын хэмжээг шалгаж, харилцагчийн бүртгэлийг мөргүүлж байх	Агуулахын орчин		Үйл ажиллагааны зардалд багтаах	Жилийн турш	“Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”
Ашиглагдаж буй химийн бодисууд урвалд орох, ажиллагсдад сөрөг нөлөөлөл үзүүлэх	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах			1500,000	Жилийн турш	
Агуулахын байранд санамсаргүйгээр гал гарах	Химийн бодисын анхааруулах самбар гаргаж агуулахын дотоод болон гадаад орчинд химийн бодистой харьцах аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээг хийх			1350,000	Жилийн турш	
	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах, Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн үнэлгээг хийлгэх Байгаль орчны аудит хийлгэх			Дотоод төлөвлөлтөөр Тохиролцсоноор	Жилийн турш Жилийн турш	
<b>Нийт</b>				<b>2,850,000</b>		

**ЗУРГАА . ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

14.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн хог хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулаагүйгээс орчинд бохирдол үүсэх	Ахуйн хатуу хог хаягдлын хогийн тусгай цэгт хуримтлуулан, гэрээний дагуу хог хаягдлын төвлөрсөн цэгт зайлуулж байх	Дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээний дагуу зохицуулагдана	-	550 000	Сард 8 удаа Жилд 96 удаа	Хог хаягдлын тухай хууль
Химийн бодисын сав баглаа бодлын хаягдал алдагдах	Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол, үлдэгдэл, хугацаа дууссан, сав баглаа боодол гэмтсэн бодисуудыг аюулгүйгээр цуглуулан өөрийн агуулахдаа хадгалах	-	-	-	Жилийн турш	“Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”
Шингэн хаягдал, химийн бодисын үлдэгдэл алдаглах	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	Ажилчид	1,500,000	1,500,000		
<b>Нийт</b>				<b>1,550,000</b>		

**ДОЛОО. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ногоон байгууламж бий болгох	“ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний хүрээнд ( “ 2014 , - ” - .)	Төслийн талбайд 1 - 50	ширхэг	50	18000	50ш x 18000Т = <b>900.0</b>	Жил бүр	
2.	Арчилгаа тордолгоо		услах	л	200	500.0	500.0		
3.	Суулгац тээвэрлэх зардал		Суулгац тээвэрлэх	км	25	100.0	100.0		
	Нийт						1 500 000		

**НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

15.

№	Үзүүлэлт	Сөрөг нөлөөллийн хяналт шинжилгээ	Хяналт шинжилгээний хэлбэр	Хугацаа давтамж	Мониторингийн цэг	Шинжилгээний багаж	Аргачлал стандарт	Тайлагнах байгууллага	Нэгжийн Өртөг / төгрөг /
1	Агаар орчны бохирдол	Агаарын хуурайшилт, агаарт агуулагдах химийн бодисын хэмжээ	Сорьцийн шинжилгээ	2023 он Жилд 2 удаа Хавар намар	Агуулахын хашаан дотор болон агуулахын дотоод орчиноос тус тус	Лабораторийн багаж	MNS4990:2000 MNS563:2001 MNSISO4221:2002	БОАЖЯ, МХГ	500,000
2	Усны бохирдол	Ундны усны хатуулаг бохирдолт	Сорьцийн шинжилгээ	2023 он Жилд 1 удаа	Төвийн шугамаас ирж буй ундны уснаас	Лабораторийн багаж	MNS900:2010	БОАЖЯ, МХГ	200,000
3	Хөрсний бохирдол	Хөрсний бохирдолын хэмжээ  Орчны хөрсний бохирдлын шинжилгээ хийлгэх	Сорьцийн шинжилгээ	2023 он Жилд 1 удаа	Агуулахын хашаан дотор	Лабораторийн багаж	MNS5850:2019	БОАЖЯ, МХГ	350,000


“Агартайж” ХХК-ийн “Картонон цаас боловсруулах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2023

Нийт зардал / 1 жилд / төгрөг	1,050,000
-------------------------------	-----------

**Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 9 050 000 мян.төг төлөвлөлөө.**

## ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Агар тайж” ХХК -н Байгаль орчны баг нь Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хариуцсан ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Бүтэц, үндсэн үүргийн талаарх мэдээллийг дараах зургаас харна уу



12.

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах	Компанийн албан ёсны page хуудас <a href="http://www.agartaij.mn">www.agartaij.mn</a>	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн	Хугацаа тодорхойгүй	Зардалгүй	ЭМААБО хариуцсан ажилчид	сошиал
2	ХХК-ийн ус ашиглалтын сар бүрийн мэдээллийг компанийн вэб хуудас <a href="http://www.ot.mn">www.ot.mn</a> олон нийтэд нээлттэй байдлаар байршуулна	Компанийн албан ёсны вэб хуудас <a href="http://www.agartaij.mn">www.agartaij.mn</a>	Ус ашиглалтын мэдээ	Жилийн турш	тодорхойгүй	ЭМААБО хариуцсан ажилчид	сошиал
3	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ХУД-н 20-р хорооны иргэдэд танилцуулах	Иргэдийн хурал цуглааны үеэр тайлагнах	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн	Хугацаа тодорхойгүй	тодорхойгүй	ЭМААБО хариуцсан ажилчид	ХУД-н 20-р хорооны иргэдийн танхим